

Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр



Амьд бие бүхэн өсөж, том болохын тулд хооллодог. Хүн ба амьтад хоол тэжээлээ эрж олохын тулд байнга хөдөлдөг. Хүн ажил хөдөлмөр эрхэлдэг. Тэгвэл ургамлын үр, ургамал яаж хооллож өсөж том болдог юм бол?

Даалгавар

1 Ургамлын эрхтнийг нэрлэж бичээрэй.



2 Ургамал ургахад зайлшгүй хэрэгтэй 4 хүчин зүйлийг зургаас сонгож тэмдэглээрэй.



3 Багш сурагчдад буудай, шошийн үрийг өгөөд хөрсөнд суулгах даалгавар өгчээ. Сурагчид аль үрийг нь гүн, алийг нь өнгөц суулгах ёстой вэ? Яагаад?



1. Буудайн үр

а. гүн



2. Шошийн үр

б. өнгөц

Яагаад?.....

4 Хамгийн том, гоёмсог цэцэглэсэн ургамлын ишийн уртыг утас, шугам ашиглан хэмжиж, хэмжих нэгжээр зөв илэрхийлэн бичээрэй.



Дууссан:сарөдөр



Өөрийн үнэлгээ:




Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр




Ангидаа ургаж буй ургамлыг ажиглан, хэрхэн өсөж, хөгжиж байгаа талаар ярилцаарай. Нэг ургамлын өсөлт хөгжлийг тасралтгүй 1 сар ажиглаж, ямар өөрчлөлт гарсан талаар тэмдэглэл хөтөлцгөө. Ингэснээрээ сурагч бидний ямар чадвар хөгжих вэ?

- 1 Өсгөгч шил хэрэглэн ургамлын навчийн судлыг сайтар ажиглаарай. Доорх ургамлын навчийн судлыг зурж дүрлээрэй.



- 2 Зурагт өгсөн термометрийн заалтыг хараарай. Ангийн агаарын хэм хэд байна вэ? Ангийн агаарын хэмийг 20 хэмээр багасгавал энэ ургамалд ямар өөрчлөлт гарах вэ? Төсөөллөө зургаар илэрхийлээрэй.



- 3 Ангид болон гэртээ ургаж байгаа ургамлын нэг навчийг сонгон, шугам ашиглан урт, өргөнийг хэмжиж, хүснэгтэд тэмдэглээд өгөгдлийг ашиглан баганан диаграмм байгуулаарай.

Сонгосон ургамлын навч	Эхний долоо хоног	2 дахь долоо хоног	3 дахь долоо хоног	4 дахь долоо хоног
Урт (мм эсвэл см)				
Өргөн (мм эсвэл см)				

Дууссан:сарөдөр



Өөрийн үнэлгээ:

